



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Ард түмний олонхийн засаглал намын  
шинэчилсэн дүрмийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Э.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ард түмний олонхийн засаглал намын шинэчилсэн дүрмийг бүртгүүлэх тухай өргөдлийг танхимын тэргүүн Д.Мөнхтуяагийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Ард түмний олонхийн засаглал намын дарга А.Батдоржоос “Улс төрийн намын тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийг үндэслэн тус намын дүрэмд өөрчлөлт оруулсан тул бүртгэж өгнө үү” гэсэн өргөдлийг 49 хуудас баримт, 1 ширхэг флаш, Улсын бүртгэлийн гэрчилгээний хамт 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн ба сонсох ажиллагааны явцад нэмэлтээр 32 хуудас баримт бичиг, 1 ширхэг флаш ирүүлснийг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Ард түмний олонхийн засаглал нам нь өөрийн намын хөтөлбөр, дүрмийг шинэчлэн бүртгүүлэхээр хуульд заасан дээрх хугацааны дотор буюу Улсын дээд шүүхэд 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдөр өргөдөл ирүүлсэн боловч хуульд

заасан шаардлагыг хангаагүй тодорхой алдаа, зөрчилтэйн улмаас тус намын шинэчилсэн дүрмийг бүртгээгүй, буцаасан байна.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар зөрчлөө зассаны үндсэн дээр дахин нэг удаа 60 хоногийн дотор намын дүрмээ бүртгүүлэх боломжийг олгосны дагуу тухайн нам нь шүүхээс тогтоосон хугацаанд өргөдлөө дахин ирүүлсэн, ингэхдээ Улсын дээд шүүхийн тогтоол, албан бичигт заасан алдаа зөрчлийг засаж, Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д заасан шаардлагад нийцүүлэн дүрмээ шинэчлэн баталж ирүүлсэн байх тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Ард түмний олонхийн засаглал намын шинэчилсэн дүрмийг бүртгэж шийдвэрлэв.

Нэг. Төлөөллийн төв байгууллагыг зарлан хуралдуулсан процессын тухайд:

Ард түмний олонхийн засаглал намын дүрэм (2018 он)-ийн 20.1-д “Намын Их хурал Бага хурлыг 45 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дараагийн Их хурал хүртэлх хугацаагаар байгуулна. Бага хурлын гишүүнээр намын Улс төрийн зөвлөлийн гишүүд шууд бусад гишүүдийг аймаг, нийслэл, дүүргийн гишүүдийн дундаас нэр дэвшүүлж саналыг нууцаар хураана”, 21.2-т “Намын Бага хурлын хуралдааныг АТОЗН-ын дарга, намын Улс төрийн зөвлөлийн санаачилгаар, эсхүл намын Бага хурлын гишүүдийн гуравны хоёр шаардсанаар зарлан хуралдуулж болно”, 21.5-д “Нийт гишүүдийн гуравны хоёроос илүү нь оролцож байгаа бол намын Бага хурлыг хүчинтэйд тооцно” гэж тус тус заажээ.

1.1.Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтуудаас үзвэл, Ард түмний олонхийн засаглал намын даргын 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 26/01 дүгээр тушаалаар Бага хурлыг 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр товлон зарлаж, хурлын товыг гишүүдэд утсаар мэдэгдсэн, тухайн Бага хуралд 31 гишүүн оролцсон, тэдгээрийг Бага хурлын гишүүд мөн эсэхийг Улсын дээд шүүхэд хадгалагдаж буй тус намын хувийн хэргээс шалгахад, 2023 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн II Их хурлын Тэргүүлэгчдийн “Бага хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай” 01/02 дугаар тогтоол, 2025 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн XVII Бага хурлын “Бага хурлын гишүүнийг чөлөөлөх, нөхөн сонгох тухай” 17/05 дугаар тогтоолоор тус тус батлагдсан Бага хурлын гишүүдийн нэрстэй таарсан, түүнчлэн өргөдөл шалгах ажиллагааны явцад тус намын дүрмийн зарим зүйл, заалт тодорхой бус байсныг сонсох ажиллагаа явуулан тодруулсан ба уг намын даргын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 26/02 дугаар тушаалаар 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр намын Бага хурлыг дахин хуралдуулсан, уг хуралд 30 гишүүн оролцсон талаар болон хуралд холбогдох бусад баримтуудыг ирүүлсэн байх тул тухайн хурлуудыг хуралдуулсан процесс дүрмийн 21.5-д заасантай нийцсэн гэж үзэв.

Хоёр.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж, Ард түмний олонхийн засаглал намын дүрэм (2018 он)-ийн 20.3.13-т “Намын Их хурлын чөлөө цагт дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг Бага хурлын хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ ...” гэж тус тус заажээ.

Улсын дээд шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02/311 дүгээр албан бичгээр тус намын Ээлжит бус Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 2511/03 дугаар тогтоолоор намын дүрмийг шинэчлэн баталж, бүртгүүлэхээр ирүүлсэн өргөдлийг “хурлын процессын хувьд зөрчилгүй боловч дүрмийн зарим заалт нь хуульд нийцээгүй, тухайлбал салбар болон бүтцийн нэгжид төрийн санхүүжилтийг нь ямар шалгуур нөхцөлөөр хэрхэн хуваарилах нь тодорхойгүй, хуулийн 41.3, 42.4-т заасан намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг орхигдуулсан, хуульд заасан үндэслэлээр түдгэлзэнэ гэсэн атлаа зөрчил гаргасан тохиолдолд түдгэлзэнэ гэж, хугацааг зохицуулахдаа түдгэлзүүлнэ гэсэн нь ойлгомжгүй, түдгэлзүүлэх үндэслэл, шийдвэр гаргах журам, шийдвэр гаргах эрхтэй этгээд болон бусад сахилгын шийтгэлийн төрлийг заагаагүй, сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацааг тусгаагүй, хяналтын төв байгууллага болон төлөөллийн төв байгууллагын гишүүнийг нөхөн сонгох талаар асуудлыг, дотоод аудиторыг нөхөн томилох талаар асуудлыг, мөн бодлогын судалгааны байгууллагын бүрэлдэхүүний тоо, эрх, үүрэг, ажиллах журам, хяналтын байгууллагын “маргаан хянан шийдвэрлэх журам”-ыг хэн, ямар журмаар батлах, намын даргад нэр дэвшүүлэх эрх, болзол шаардлагыг тусгаагүй, хуульд заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглох, хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авахыг, татвараас хөнгөлөх, чөлөөлөх эсэх нь тодорхойгүй” зэрэг алдаа зөрчлийг дурдаж, буцаасан.

Ард түмний олонхийн засаглал намын төлөөллийн төв байгууллага болох Бага хурал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр, 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр тус тус хэлэлцээд төлөөлөгчийн 100 хувийн саналаар дүрмийн өөрчлөлтийг баталсан нь Тооллогын комиссын 2026 оны 02/03, 2/06 дугаар тогтоол, Бага хурлын 2026 оны 02/04, 02/07 дугаар тогтоол, хурлын тэмдэглэлүүд, фото зураг, дүрс бичлэг болон бусад бичгийн баримтаар тогтоогдож байна.

Ард түмний олонхийн засаглал намын Ээлжит бус Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 2511/03 дугаар тогтоолоор баталсан намын дүрэм нь нийт 368 буюу 20 бүлэг, 47 зүйл, 159 заалт, 142 хэсэгтэй байсан, үүнээс 1 бүлэг, 4 зүйл, 23 заалт, 7 хэсэгт өөрчлөлт оруулж, 9 заалт, 16 хэсэгт нэмэлт оруулж, 1 заалт, 2 хэсгийг хасаж, нийт дүрмийн 63 буюу 17.12 хувьд нь нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 17.4-т заасантай нийцсэн байна.

Ард түмний олонхийн засаглал намын дүрэм нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.2.1-15.2.10-т заасан нийтлэг шаардлагыг хангасан байх тул Ард түмний олонхийн засаглал намын дүрэм нь бүхэлдээ Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцсэн гэж үзэхээр байна.

Иймд, Ард түмний олонхийн засаглал намын шинэчилсэн дүрмийг бүртгэж шийдвэрлэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь заалтыг баримтлан Ард түмний олонхийн засаглал намын шинэчилсэн дүрмийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ,  
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.МӨНХТУЯА